

Т.Одончимэг

Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн Нийгмийн Ухааны тэнхимийн багш

ӨНӨӨГИЙН ОЮУТНЫ ТӨЛӨВШЛИЙН ХЭВ ШИНЖ

Abstract: As the future of any country is dependent upon its youths, students as one of the largest constituencies of them is an important part in personality study. Both Mongolian and foreign scholars has been studying them from their own field of studies. Among them, the studies on students James Coleman, Martin Trow, and studies to discover relations and norms of psychological aspects of Mongolian students are of great methodological importance. Studies of James Coleman, Martin Trow showed that micro social groups and peers have strong effect on the development of an individual. Martin Trow classified students into "conformist", "vocational", "academic" and "non-conformist" on the basis of his study on college students. Mongolian psychologists also found that apart from gender, geographical and demographic factors temperament and response time, and intellectual ability determines students learning processes, humanism and communication skills and assessed the norms. Today, the study on students shows that they have a very pragmatic approach to academic endeavor having their motivation largely determined by the necessity and applicability of the knowledge and subjects.

Key words: values, attitudes, "conformist", "vocational", "academic" and "non-conformist"

Монгол бие хүний судалгаанд монгол оюутны талаарх судалгааны ажил жинтэй хувь нэмэр эзлэх нь дамжиггүй. Учир нь оюутнууд бол манай хүн амын дийлэнх хувийг эзэлдэг хүүхэд, залуучуудын томоохон бүрэлдэхүүн, хойч үеийнхний бүх талын хөгжлийг тодорхойлогч гол хүч. Монгол орны хувь заяанд залуу үеийнхэн үлэмж хэмжээгээр нөлөөлдөг. Оюутнууд нь нийгмийн байр суурийн хувьд нэрт социологич Х.Гүндсамбуу агсны бичсэнчлэн "...завсрын, дундын, шилжимтгий байр сууринд байдаг".¹ Энэ завсрын шилжимтгий торгон мөчид бие хүний ямар шинж хэрхэн бүрэлдэн төлөвшихөөс цаашдынх нь хувь заяа нэлээд хэмжээгээр хамаарна. Ийм ч учраас гадаад, дотоодын олон эрдэмтэн тэднийг өөр өөрийн салбарын онцлогийн үүднээс судалсаар ирсэн байна. Тухайлбал, АНУ-ын эрдэмтэн Жеймс Коулман, Мартин Троу нарын судалгаагаар

суралцагчдын бие хүний төлөвшилд нийгмийн бичил бүлэг ялангуяа үе тэнгийнхэн нь онцгой үүрэг гүйцэтгэдэг болохыг олж тогтоожээ. Мартин Троу коллежийн түвшинд хийсэн судалгаан дээрээ үндэслэн оюутнуудыг "хамт олонч", "мэргэжигч", "академич", "үл эвлэрэгч" гэсэн хэв шинжид хуваан авч үзжээ. "Хамт олончид" эрдэм ном, сурлагаас үдэшлэг, спорт, урлаг, уран сайхныг илүүд үздэг, "мэргэжигчид" сайн суралцахыг хүсэх боловч ирээдүйн ажил албанд нь төдийлөн ач холбогдолгүй гэж үздэг учраас эрдмийн ажилд шамддаггүй, "академич" нар бол ашгийн төлөө бус үнэн сэтгэлээсээ суралцдаг, "үл эвлэрэгч" нарын хувьд амиа аргацаагчид бөгөөд эрдэм мэдлэг, урлаг, спорт, мэргэжлийн алиныг нь ч үнэ цэнтэй гэж үздэггүй, амьдралын онцгой хэв маягийг үнэлж, нийгмийн зонхилох үнэт зүйлсийг шүүмжлэн үздэг ажээ. Эдгээрийн аль нь давамгайлах нь нийгмийн нөхцөлөөс хамаардаг байна. Тухайлбал, 1920 болон 1980-аад оны "хамт олонч"-д, 1930, 1940-өөд оны үед нийгэмд бий болсон эдийн засгийн уналт, улс төрийн үл эвлэрэл зэрэгтэй холбоотойгоор "үл эвлэрэгч"-д, 1950-иад оны үед дэлхийн дайн дуусаж, тайван сайхан жирийн амьдралыг амжилт бүтээлээр дүүрэн өнгөрүүлэхийг хүссэн цэргүүд буцан ирж шинжлэх ухаан болон мэргэжлийн сонирхол эн тэргүүнд тавигдах болсонтой холбоотойгоор "мэргэжигч" болон "академич" нар 1960-аад онд иргэний эрхийн төлөө хөдөлгөөн өрнөж, оюутнууд вьетнамын дайныг эсэргүүцэн тэмцэх болж, улс төр болон гоо зүйн хувьд үл эвлэрэх хандлага сэргэсэнтэй холбоотойгоор "үл эвлэрэгч"-ид, 1970-аад онд дайн дуусаж, эдийн засгийн хямрал бий болсон нь мэргэжлийн сонирхлын ач холбогдлыг өсгөж, оюутнууд ирээдүйн ажил төрөлдөө санаа тавих нь ихсэхийн хэрээр шинжлэх ухаан улс төрд хайхрамжгүй хандах болсонтой холбоотойгоор "мэргэжигч" нар давамгайлж байсан байна.²

Монгол оюутны талаар Ж.Даваа, Л.Жамц, Ц.Содов, Г.Сүхбат нарын бусад сэтгэл судлаачид өнөөгийн монгол оюутны сэтгэл физиологийн зарим үзүүлэлтүүдийг тодорхойлсон нь нэлээн суурь шинжтэй дорвитой судалгаа болжээ. Судалгаанаас темпераментийн хувьд монгол оюутнуудын дунд меланхолик араншин хамгийн

¹ Гүндсамбуу, Х. Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага. Уб., 2002. х.548

² Смелзер. Н. Социологи. Орч. Уб., 2001. х.416



түгээмэл, холерик араншин хамгийн цөөн, оюуны чадавхын хувьд эрэгтэй эмэгтэй адил, харилцах чадварын хувьд дунд зэрэг боловч эрэгтэйчүүд нь арай илүү байгаа нь харагдсан байна. Мөн оюуны чадавхын түвшин дээшлэх тусам харилцах чадвар сайжрахын зэрэгцээ хотын оюутнууд хөдөөгийнхнөөсөө энэ тал дээр илүү байжээ. Аль ч араншингийн хувьд оюуны чадавхын дундаж түвшин давамгайлж байгаа боловч сангивиник, флегматик болон эдгээрийн хослолтой эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс оюуны чадавх өндөртэй, сангивиник, флегматик, сангивиник-флегматик оюутнууд бусдыгаа бодвол харилцах чадвар сайтай гарчээ. Тэрчлэн эрэгтэй оюутнууд хараа ба сонсголын түр багтаамжаараа эмэгтэйчүүдээс илүү болохын зэрэгцээ тэдний харааны ойн багтаамж нь сонсголынхоосоо мэдэгдэхүйц сайн байжээ.

Оюутнуудын санаа бодлоо илэрхийлэх хариу урвалын хурд, сэтгэл хөдлөлийн байдлаар дунд зэрэг, уян хатан, идэвхтэй шинжээрээ сайн байжээ. Мөн идэвхтэй, хариу урвалын хурд сайтай, уян хатан оюутнуудын сурлагын амжилт илүү, анагаахын чиглэлээр суралцаж буй оюутнууд хүмүүнлэг чанарын хувьд бусдаасаа илүү, техникийн чиглэлээр суралцаж буй оюутнууд хүмүүнлэг чанарын хувьд хамгийн хангалтгүй, хүмүүнлэг чанарын хувьд сулхан үзүүлэлттэй эмэгтэйчүүдийн дийлэнх нь хотынх, эрэгтэйчүүдийн дийлэнх нь хөдөөгийнх байжээ. Хүмүүнлэг чанарын үзүүлэлт сайжрах тусам эрүүл мэнддээ анхаарах, санаа бодлоо илэрхийлэх чадвар, идэвх, хариу урвалын хурд зэрэг нь нэмэгдэж байжээ.

Түүнчлэн Х.Гүндсамбуу агсан одоогоос арваад жилийн өмнө оюутнуудыг социологийн үүднээс, залуучуудын томоохон, өвөрмөц, завсрын давхраа болохынх нь хувьд тэдний элсэлт, төгсөлт, тооны өсөлт, хүйсийн харьцаа, мэргэжил сонголт, сонирхол, сэтгэл ханамж, хамт олонсог байдал, үнэт зүйлс, амьдралын төлөвлөгөө, төрөлх хэл, гадаад хэл, компьютерийн мэдлэг зэрэг зарим нэг ур чадваруудынх нь талаар судлан социологийн үүднээс дүгнэлт хийжээ.³ Мөн судлаач багш П.Эрдэнэбат, Б.Аззаяа нар оюутны хөгжил, төлөвшлийг үнэлэх хүчин зүйлүүдийг тодорхойлсон⁴ бол сурган хүмүүжүүлэх шинжлэх ухааны доктор, профессор Д.Нямжав монгол оюутны танин мэдэх үйл ажиллагааг орос хэлний сургалтын явцад идэвхжүүлэх туршилт судалгааг хийсэн байна.⁵

Миний хувьд тэдний эрхэлдэг гол үйл ажиллагаа болох сурах үйл явцдаа хандах хандлагыг нь сонирхон судалсан юм. Ингэхдээ манай эрдэмтдийн боловсруулсан бэлэн анкетын

шууд авч ашигласан болно. Судалгаанд нийтдээ 10 их, дээд сургуулийн 415 оюутныг хамруулсан юм.

Хандлага бол хүний үйл ажиллагаа, зан үйл, үйлдлийн үндсэн утга, учир шалтгааныг өөртөө агуулсан бие хүний хэрэгцээ, сэдэл сонирхол, ертөнцийг үзэх үзэл, тогтсон хандлага, амьдралын зорилгын хамгийн цомхон илрэл нь юм. Хандлагад хэрэгцээн дээр үндэслэгдсэн, ямар нэг үйлдэл, үйл ажиллагаанд өдөөн оруулах дотоод хүчин зүйл болох сэдэл, сонирхол хамгийн ихээр нөлөөлнө.

Тэгэхлээр манай оюутнуудын сурах үйл ажиллагааны үндсэн утга, учир шалтгаан нь юу вэ? гэдгийг судлахад үнэхээр сонирхолтой байв. Ингэхдээ өнөөгийн нийгмийн нөхцөл байдалтай холбоотойгоор **“оюутнуудын дунд суралцах үйл ажиллагааны прагматик хандлага давамгайл бөгөөд үүнтэй холбоотойгоор “мэргэжигч” хэв шинжийн оюутнууд зонхилно”** гэсэн таамаглал дэвшүүлсэн нь судалгааны үр дүнгээр батлагдсан юм.

Оюутнуудын дийлэнх нь суралцах үйл ажиллагаандаа аль нь үр ашигтай вэ? гэсэн сэдлээр ханддаг бололтой. Энэ байдлыг харуулсан дараах статистикт анхаарлаа хандуулъя.

Танд ямар сурах бичиг таалагддаг вэ?

Сурах бичгийн төрөл, хэлбэр	Тоо	Хувь
Курс дамжаа төгсөхөд хэрэг болох	55	13,3
Төгсөөд ажил хийхэд шууд хэрэг болчихоор	100	24,1
Ойлгомжтой хэллэгээр бичигдсэн	77	18,6
Даалгавар нь түвэгтэй биш амархан	51	12,3
Чухал мэдлэг олж авчихаар	143	34,5
Мэргэжлийн материал их орсон	182	43,9
Шинжлэх ухааны хэллэгээр бичигдсэн	21	5,1
Ашигтай, ач холбогдолтой даалгавар их орсон	54	13,0

Тэд мэргэжлийн материал их орсон сурах бичгийг хамгийн их хувьтай /43,9%/, харин шинжлэх ухааны хэллэгээр бичигдсэн сурах бичгийг хамгийн бага хувьтайгаар /5,1%/ сонгожээ. Эндээс харахад, манай оюутнуудын дунд “мэргэжигч” хэв шинжийн оюутнууд хамгийн олон “академич” хамгийн цөөн гэж хэлж болохоор байгаа юм.

“Мэдлэг бол хүч мөн” гэсэн Бэконы үзэл санаа Өрнөдийн орнуудад шинжлэх ухаан эрчимтэй хөгжиж, аж үйлдвэржилтэд нэвтрэх үйл явцын үр дүн, шинжлэх ухаан үйлдвэрлэл хоёрын хоорондын холбооны мөн чанарыг илэрхийлж гарч ирсэн. Энэ үзэл бол капиталист үйлдвэрлэлийн оюун санаа, сэтгэлзүйн нэгэн чухал суурь нь болсон юм. Учир нь “мэдлэг бол хүч мөн” гэдгээс “мэдлэг бол ашиг мөн” гэсэн гаргалгааг хялбархан хийж болно. Тэгвэл манай ирээдүйн хамгийн сэхээлэг хэсгийнхний сэтгэхүйд энэ үзэл санаа ерөнхийдөө, ялангуяа шилжмэл хэлбэрээрээ нэгэнт суусан байна. Бодит байдал дээр оюутнуудын маань мэдлэг, чадвар

³ Гүндсамбуу.Х. Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага. Уб., 2002. х.548-565

⁴ Боловсрол судлал. Уб., 2003\02

⁵ Боловсрол судлал. Уб., 2002\03

хэр байгааг түр мартагнаад хэлэхэд байгалийн нөөцийн хомсдол, эко системийн тэнцвэргүйжилт болон том эдийн засагтай том орнуудад ашигтай, жижиг эдийн засагтай жижиг орнуудад тэднийг улам л хөгжлөөс таслах маягаар ерөнхийдөө ашиггүйгээр өрнөж буй даяаршлын нөлөө зэрэг нь л саад болчихдоггүй юм бол эрчимтэй аж үйлдвэржилтийн сэтгэл зүйн нэгэн чухал үндэс бидний хойч үеийнхний сэтгэхүйд соёолсон байна. "Түүх мартагддаг хэдий ч давтагдах нь цөөнгүй" хэмээн нэрт судлаач агсан багшийн минь бичсэн үгэн ажгуу. Үүнийг таамаглалын үндэслэлийг шалгах зорилготой удаах асуултад хариулсан байдлаас харж болно.

Та ямар даалгавар гүйцэтгэх сонирхолтой вэ?

Даалгаврын төрлүүд	Тоо	Хувь
Шинэ мэдлэг эзэмшихэд тохирсон	162	39,0
Бие даан ажиллах боломжтой	95	22,9
Янз бүрийн орчин үеийн техник хэрэгсэл ашиглах боломжтой	92	22,2
Багаар ажиллах	114	27,5
Өөрийн үзэл бодлыг илэрхийлэх боломжтой	117	28,2

Шинэ мэдлэг эзэмшихэд тохирсон даалгаврыг гүйцэтгэх сонирхолтой гэж хамгийн олон хувьтай хариулсан байгаа \39%\-г харж болно. Удаах байранд өөрийн үзэл бодлыг илэрхийлэх боломжтой даалгавар 28,2%, багаар ажиллах боломжтой даалгавар \27,5%\ байгаа нь санамсаргүй хэрэг биш юм. Манай оюутнууд Маслоугийн хэрэгцээний онолын үүднээс авч үзвэл өндөр эрэмбийн хэрэгцээтэй болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, сэдэл, сонирхол хэрэгцээн дээр суурилж гарч ирдэг. Өөрийгөө илэрхийлэх, хэрэгжүүлэх хэрэгцээ бол өндөр эрэмбийн хэрэгцээнд тооцогдохын зэрэгцээ бас жам ёсны ч үзэгдэл юм. Учир нь оюутан нас бол өөрийгөө илэрхийлж, иргэн болох эхний үе шат юм. Энэ насанд бие хүний үндсэн бүрдэл буюу зан төлөв, чиг хандлага, ертөнцийг үзэх үзэл, өөрийн ухамсар үндсэндээ төлөвшчихсөн, хэрэгцээ сонирхол нь тогтворжин, өөрийгөө шинжин таньж илэрхийлэх эрмэлзэл, чадвартай болдог. Ийм учраас зарчимч чанар хөгжин, аливаад өөрийн байр сууринаас хандан үнэлж, дүгнэх чадвар сууна.

Харин багаар ажиллах даалгавар гүйцэтгэх сонирхолтой гэдгийн хувьд нэг талаас багаар ажиллах сонирхолтой, хамтын сонирхол, бүлгийн сэтгэхүй, хамтач зан үйл сайн хөгжсөн мэт боловч цаана бас монгол хүний сэтгэлгээнд бүр зуршмал байдаг хамтаараа хийсэн нийт дундын аливаа үйлд хэн нэгэнд хариуцлага хүлээлгэхэд хэцүү байдаг, амжилттай боллоо гэхэд багийн бүх гишүүд хэр зэрэг хөдөлмөрлөснөөс үл хамааран бүгд үр шимийг нь хүртэх боломжтой байдаг зэргийг тооцож үздэг байхыг үгүйсгэх аргагүй. Эриксон энэ насыг ид насны эхэн үе \20-25\ гэж нэрлээд дотносох ба зожигрохын зөрчил илэрнэ

гэж үзсэн нь нэлээд үндэстэй болох нь харагдаж байна.

Бие даан ажиллах боломжтой даалгаврын хувьд харьцангуй сулхан үзүүлэлттэй байгаа нь \22,9%\ өсвөр наснаас залуу насанд шилжих шилжилтийн үеийн онцлог, хямралын илэрхийлэл гэлтэй. Энэ насныхан бүх юманд бүрэн бие даах чадваргүй, цаг нь ч хараахан болоогүй байгааг судалгааны энэ дүн ямар нэг хэмжээгээр илтгэнэ.

Оюутнууд чухам ямар сэдлээр суралцах сургуулиа сонгодгийг олж илрүүлэх зорилготой асуултаар тэдний сайн багш, чанартай сургалтыг сонгож байгаа нь тодорхой болсон юм.

Таны суралцдаг сургуулийн чухам юу нь танд таалагддаг вэ?

	Тоо	Хувь
Материаллаг бааз сайтай	81	19,5
Багш нарын мэдлэг чадвар сайн	189	45,5
Оюутнуудынх нь өвөрмөц харилцаа	46	11,1
Хичээлээс гадуур олон нийтийн үйл ажиллагаа их явуулдаг	32	7,7
Сургуулийн нэр хүнд сайн	98	23,6
Сургалт нь чанартай	116	28
Төлбөрөө төлчихсөн байхад ерөнхийдөө амархан төгсчихдөг	19	4,6

Багш нарын мэдлэг чадвар сайн \45,5%\, сургалт нь чанартай \28%\ гэдэг хоёр хариулт хамгийн өндөр хувьтай байгааг анзаарч байгаа байх. Энд нэг зүйлийг тэмдэглэж хэлэхэд яг бодит байдал дээр тухайн сургуулийн багш нар үнэхээр өндөр үр чадвартай юу, сургалт нь чанартай юу, тэдгээрт оюутан бодитой үнэлгээ өгч чадаж байгаа эсэх зэрэг нь өөр асуудал юм. Хамгийн гол учир нь өндөр үр чадвартай багш, сайн сургалт чухал гэдгийг онцолсон байгаад л оршино.

Оюутны бие даах ажлыг зарим хүн номын хуулбар, ямар ч хэрэггүй зүйл гэж үнэлдэг ч үнэндээ бол тийм биш юм. Чухамхүү энэ бие даалтын ажлаар л тухайн оюутны ерөнхий мэдлэгийн түвшин, бие даан болон багаар ажиллах чадвар, мэдээлэлтэй харилцах, анализ, синтез, дүгнэлт хийх зэрэг чадварынх нь олон үзүүлэлтүүд бодит амьдрал дээр хөгжиж, хэрэгжиж өгөөжөө өгөх учиртай юм. Өөрөөр хэлбэл, бие даалтыг жинхэнэ утгаар нь хийвэл маш хэрэгтэй зүйл.

Бие даалтын ажил ямар байвал зүгээр вэ?

	Тоо	Хувь
Асуудал дэвшүүлсэн	91	21,9
Хүндэвтэр, нэмэлт нөхцөл шаардсан	48	11,6
Өмнөх мэдлэг чадварыг шавхан дайчилсан	165	39,8
Шууд амархан гүйцэтгэхээр хөнгөвтөр	54	14,0
Шинэ мэдлэг эзэмшиж байж л гүйцэтгэх боломжтой	114	27,5
Хугацаа их зарцуулахуйц	35	8,4
Хугацаа бага зарцуулахуйц	75	18,1

Дээрх үзүүлэлтүүдийг хараад оюутнуудын



дунд багагүй хугацааг өнгөрүүлж, тэдний сэтгэц, зан үйлийг байнга ажиглан байдаг миний хувьд үнэмшилгүй санагдан, гайхаж байв. Учир нь өнөөгийн манай боловсролын систем хүүхдийг хүн хөдөлмөрлөхийг буюу багшийн хичээл заахыг идэвхгүйгээр харж суудаг, идэвхгүй бие хүнийг түлхүү төлөвшүүлээд байгаа нь бүр илт харагддаг. Багш хичээл заах үед манай дийлэнх хүүхдүүд суугаад л сонсох нь сонсож, бичих нь бичдэг. Харин яг жинхэнэ өөрийнх нь хөлс хөдөлмөр, мэдлэг чадвар шаардсан даалгавар гүйцэтгэх болохоор ихэнх нь маш дургүй, огт өөр болчихдог. Судалгаанд оролцогчийн байр байдалтай уг асуудлыг холбосон харьцуулсан тоололтыг авч үзвэл бүр илүү нарийн учиг тодорч болох юм.

Ер нь өндөр мэдлэг, мэргэжлийн нарийн үр чадвар манай оюутнуудын хувьд өнгөц мэдлэгийн хэмжээнд чухал байгаа бололтой. Энэ нь итгэл үнэмшил, бүр жинхэнэ үнэлэмж болох хэрэгтэй байна. Мэддэг зүйл итгэл үнэмшил, үнэлэмж болоогүй цагт үйлдэлд бодитойгоор илэрдэггүй, хэрэгждэггүй. Худал хэлж болохгүй гэдгийг бид бүгд мэддэг, тэгж сургадаг, тэгсэн атлаа бид энэ буруу үйлээ өдөр тутамдаа байнга хийдэг. Үүний нэгэн адил ажгуу.

Хийсэн судалгааныхаа статистик боловсруулалтын дан тоололт дээр үндэслэсэн үр дүнгийн талаар өгүүлэхээ энд хүрээд түр өндөрлөө дөө. Харьцуулсан тоололт дээр үндэслэсэн сонирхолтой үр дүнг өгүүлж амжаагүйдээ хүлцэл өчье. Дараагийн удаад илүү нарийн учгийг тодруулан өгүүлж чадах тийм үр дүнтэй анализ, дүгнэлтийг та бүхэнд толилуулах болно.

ДҮГНЭЛТ

1. Бие хүний шинж чанар, хөгжил төлөвшил, ухамсар зэргээс нийгмийн хувь заяа шалтгаалдгийн нэгэн адил нийгмийн ахуй нь ч гэсэн бие хүний шинж, онцлог, хэв шинжид нөлөөлдөг давхар шалтгаалтай ажээ. Өөрөөр хэлбэл, оюутны чиг хандлага, үнэлэмж, төлөвшлийн хэв шинж бүрэлдэн тогтоход өнөөгийн Монгол орны нийгмийн нөхцөл байдал шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэж байна.
2. Оюутнуудын бие хүний шинж, үйл ажиллагаа, хөгжил төлөвшилд тэдний хүн ам зүйн шинж болон сэтгэцийн үзэгдлүүдийн онцлог нь тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.
3. Өнөөгийн монгол оюутнуудын дунд суралцах үйл ажиллагааны прагматик хандлага давамгайл бөгөөд үүнтэй холбоотойгоор "мэргэжигч" хэв шинжийн оюутнууд зонхилж байна.
4. Өнөөгийн оюутнуудын үзэл санаанд өндөр мэдлэг боловсрол, мэргэжлийн нарийн

ур чадвар чухал байр суурь эзлэх боловч энэ нь өнгөцхөн түвшинд, тэдний итгэл үнэмшил, үнэлэмж болж чадаагүй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Даваа, Ж., Жамц, Л., Содов, Ц., Сүхбат, Г. (2009). *Боловсрол судлалын үндэс*. Улаанбаатар
- Гүндсамбуу, Х. (2002). *Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага*. Улаанбаатар
- Гидденс, А. (2006). *Социологи.орч*. Улаанбаатар
- Смелзер, Н. (2001). *Социологи*. Орч. Улаанбаатар
- Боловсролын хүрээлэн. (2002. 03). *Боловсрол судлал сэтгүүл*. Улаанбаатар
- Боловсролын хүрээлэн. (2003.02). *Боловсрол судлал сэтгүүл*. Улаанбаатар

